

ХУБИЛАЙ ХААНЫ АЗИД ЯВУУЛСАН БОДЛОГО

Д.Дашдулам*

Монголчууд төрт улсаа байгуулсан олон зуун жилийн түүхтэй ард түмэн билээ. Тэр дундаа Монголын Их Эзэнт гүрний үе нь Монголын төдийгүй дэлхийн түүхэнд онцгой байр эзэлдэг юм. XIII-XIV зуун монголчуудын хүчирхэгжилтийн үе төдийгүй гадаад ертөнцөд өөрсдийгээ нээсэн, идэвхтэй гадаад бодлого явуулсан чухал үе байсан юм.

Чингэс хаан болон түүнийг залгамжлагчид Европ, Азийн ихэнх улсыг өөрийн захиргаанд нэгтгэж, хүчирхэг төвлөрсөн улсыг өнө удаанаар байгуулсан түүхийг түүний өмнө болон дараагаар дэлхийн хаана ч, хэн ч давтаж чадаагүй нь маргаангүй үнэн билээ. Чингэс хаан болон түүний залгамжлагчдаас явуулсан цэрэг, дайны үйл ажиллагаа, агуу их ялалтууд нь дэлхийн цэргийн түүхэнд ч мөн онцгой байр эзэлдэг юм.

Би энэхүү илтгэлдээ Хубилай хаанаас явуулсан дайны шинж чанарыг тодорхойлох зорилго тавиагүй бөгөөд харин Азид явуулсан цэрэг, дайны болон нийгмийн бодлого юу байсан талаар өгүүлэхийг хүсэж байна. Ингэхдээ Монголын Эзэнт Гүрний үеийн байлдан дагуулалт, цэрэг дайны түүхэнд гунигтай хэдий ч нэн бүрхэг байдаг Хубилай хаанаас Япон руу хийсэн 2 удаагийн цэргийн ажиллагаа яагаад амжилтгүй болсон, үнэхээр далайн шуургатай холбоотой байсан уу, аль эсвэл өөр хүчин зүйл нөлөөлсөн үү гэдэг талаар, мөн Хубилай хааны түүхэнд гүйцэтгэсэн үүргийг тодруулан өөрийн үзэл бодлыг илэрхийлэхийг зорьсон юм.

Монголын Их хаан Мөнхийн зарлигаар Хубилай нь Умард Хятадын эзлэгдсэн газар нутгийг захиран сууж байсан ба 1260-1271 онд Монголын эзэнт улсын хаан ширээнд сууж улмаар 1271 оны 1-р сараас “Их Монгол Улс”-ын нэрийг “Их Юан Улс” болгон өөрчилсөн байдаг.

* МУИС-ийн НШУС-ийн багш, доктор(Ph.D)

Хубилай хаан нь Эзэнт гүрний төрийн жолоог аваад өвөг дээдсийнхээ уламжлуулан үлдээсэн төрийн дотоод болон гадаад бодлогын үндсэн зарчмыг тууштай баримтлан, залгамж холбоог алдагдуулаагүй ирсэн нь ялангуяа цэрэг болон дипломатын талаар явуулсан бодлогод нь тодорхой харагддаг юм. Тэрбээр Европ, Азийн ихэнх улсуудыг хамарсан Эзэнт улсынхаа аюулгүй байдлыг хамгаалах хүрээнд өөрийн өвөрмөц бодлогыг хэрэгжүүлж, Юан улсын эрхшээлд цэргийн болон дагаар орсон улс үндэстнүүдийг удаан хугацаагаар ноёрхолдоо байлгахын тулд улс, үндэстнүүдийн онцлогийг харгалзсан зохион байгуулалт хийж, төрийн бодлогыг явуулсан байдаг.

Хубилай хаан Дорно зүг идэвхтэй бодлого явуулж Хятадыг бүхэлд нь эзлэн эрхшээлдээ оруулж улмаар Зүүн Ази, Өмнө Азийн улсуудтай харилцаа тогтоохыг чухалчилж байлаа. Ингэхдээ Солонгосоор дамжуулан Японтой, Өмнөд Хятадын нутгаас Зүүн өмнөд Азийн улсуудтай харилцаа тогтоон өөрийн хараат улс болгохын тулд дипломатын болон цэргийн идэвхтэй бодлого явуулжээ.

Хубилай хааны Ази руу явуулсан бодлогын зорилго, үр дүн юу байв гэдэг талаар Сүн улс, Төвд, Солонгос, Зүүн өмнөд Азийн улсуудтай харилцсан байдлаас харж болох юм. Хубилай хаан болсныхоо дараагаас эхлээд өмнөх Их хаадын Өмнөд Хятадыг эрхшээлдээ оруулах олон жилийн цэргийн ажиллагаагаа идэвхжүүлэн улмаар бүх Хятадыг эзлэн Эзэнт улсынхаа хил хязгаарыг тэлэх зорилго тавьсан юм. Ингэхдээ Өмнөд Сүн улсынханы дотоод зөрчил хурцадмал байсныг ашиглаж байсан хэдий ч ард түмэн нь шийдвэртэй эсэргүүцэж байсан тул эзлэн авахад бас тийм ч хялбар байгаагүй юм. Иймээс байлдах тактикийг өөрчлөн хэд хэдэн чиглэлээр цэрэг оруулах, дагаар орогсдын хүчийг ашиглах, бүслэн хааж хоол хүнсээр гачигдуулах зэрэг олон арга хэрэглэсний дүнд 1279 онд Өмнөд Сүн улс мөхөж улмаар Хятадын бүх нутаг монголчуудын эрхшээлд орсон юм.

Хубилай хаан бүх Хятадыг эрхшээлдээ оруулаад нэгдмэл захиргаанд барьж байх зорилгоор засаг захиргааны өөрчлөлт хийсэн төдийгүй эдийн засаг, аж ахуйн онцлогийг харгалзан тариа, хөвөнгийн тариаланг эрчимтэйгээр эрхлүүлэх болж усалгааны суваг шуудууг олшруулснаар ургацын хэмжээг нэмэгдүүлж чаджээ. Мөн хот, тосгодод улсын болон албаны үйлдвэр байгуулан шаазан эдлэл хийх, бөс даавуу болон сайн чанарын торго нэхэх болсон нь нэг талаар дотоодын үйлдвэрлэл өсч байдлыг дээрдүүлсэн, нөгөө талаар өрнө, дорныг холбосон худалдааны шинэ шинэ замыг дагаад олон улсуудын гадаад худалдааны хөгжилд сайнаар нөлөөлсөн гэж үзэж болох юм.

Хубилай хаан Төвдийг эрхшээлдээ оруулахдаа зэвсгийн хүч хэрэглэхээс илүү тэдний сүм хийд, лам нарын нөлөө нийгэмд илүү байгааг гярхай харж харьцангуй хялбараар зорилгоо биелүүлсэн юм. Бурханы шашныг гүрний гол шашин болгосноор олон хэл, шашинтай улс, үндэстнүүдийг нэг шашны дор нэгдмэл захиргаанд оруулах бололцоог олгож, лам нар төрийн онцгой халамжинд орж, эрх ямба эдлэх болжээ. Бурханы шашинг дэлгэрүүлэхэд “Улсын багш” хэмээн өргөмжлөгдсөн Пагва лам их үүрэг гүйцэтгэсэн төдийгүй Хубилай хааны итгэмжит, нөлөөтэй хүн болсон юм.

Юан улсын гадаад бодлогын нэг чухал хэсэг бол Зүүн өмнөд Азийн улсуудтай харилцаа тогтоох явдал байсан ба элчээр дамжуулан дагаар орохыг ятган эс дагаваас хүч хэрэглэнэ гэдгийг мэдэгдэж байжээ. Үүнийг улс бүр дотоод болон гадаад хүчин зүйлүүдээсээ шалтгаалан янз бүрээр хүлээн авсан байдаг. Тухайлбал, Аннам (Вьетнам)-тай 1260-аад оны үед нилээд найрсаг харилцаж бэлэг сэлт солилцож байжээ. Гэвч 1270-аад он болоход алба барих үүргээ умартах болсон зэрэг нь харилцаа хүйтрэх шалтгаан болжээ. Хүлээсэн үүргээ биелүүлээгүй, нөхцөл байдлыг мэдрээгүй Аннамд зайлшгүй цохилт өгөх шалтгаан Юан гүрэнд байсан төдийгүй нөгөө талаас өмнөд далайн улсуудыг эрхшээлдээ оруулахад Аннам түшиц газар болох байлаа. Аннамыг дайлахаар 1285, 1287 онуудад их цэрэг илгээсэн боловч цаг агаар болон газар орчныг сайн мэдэхгүйн улмаас ялагджээ. Гэсэн хэдий ч Аннам элч илгээж алба барьсан хэвээрээ байснаас харах юм бол хараат улс гэдгээ хүлээн зөвшөөрсөөр байжээ.

Юаны цэргүүд 1253 онд Дали улсыг эзэлснээр Бирм буюу Паган улстай шууд хил залгаа орших болсон ба 1272, 1277 онуудад Бирмийн хойд хэсгээр орж Дали улсын харъяанд байгаад хожим алдагдсан хэд хэдэн газрыг Юаны мэдэлд авчээ. 1283 онд Бирмийн умард хэсэг, 1285 онд төв Бирм удалгүй өмнөд Бирмд дагаар орох болсноор бүхэлдээ Юаны мэдэлд шилшиж алба барих болжээ. Хубилай хаан Чампа (Вьетнамын өмнөд хэсэг) улсад анхны элчийг 1278 онд хоёр дахь элчийг 1280 онд илгээсэн ба 1279 оноос алба барих болжээ.

Энэтхэг-Хятадын хойгийн Аннам, Чампа, Комбож, Бирм зэрэг улсууд нь 1287 он гэхэд Юаны эрхшээлд бүрэн орж алба барьж байсан ба урьд нь тэд нар дагаар орохоо илэрхийлсэн хэдий ч Хубилайн элчийг баривчлах, элчид хариу өгөхгүй удах, хаад нь байгалийн бартааг ашиглан уул, хаданд дүрвэн удаан хугацаагаар зугтах, алба барихаа илэрхийлсэн боловч хугацаандаа барихгүй байх зэрэг янз бүрийн арга саам хэрэглэж байлаа.

Юан улс болон Солонгостой харилцах харилцаа бусад улсуудынхаас ихээхэн өвөрмөц байсныг хэлэх хэрэгтэй. Солонгос нь Монголын эрхшээлд орж, Юан гүрний стратегийн бодлогын хүрээнд гадаад улс төрийн бодлого нь зохицуулагдаж байсан хэдий ч вант төр нь үйл ажиллагаагаа явуулсаар байлаа. Ялангуяа хоёр улсын эрх баригчдын хоорондын холбоо туйлын ойр дотно байсны илрэл нь төрийн ураг барилдсан явдал юм. Юан гүрний оршин тогносон 100 гаруй жилийн хугацаанд Солонгосын эрх барьсан 7 вангийн тав нь Хубилай болон Монголын бусад хаад, ноёдын гүнж тэдний удам угсааныхантай гэрлэж Юан гүрний сүүлийн хаан Тогоонтөмөр солонгос угсааны хатантай байжээ (1-90).

Солонгосын вангийн хувьд монгол гүнж авч ураг барилдах болсноор дотоодын зөрчил, тэмцлийг намжаахдаа Юан гүрний дэмжлэгийг авч вангийн удам угсааныханы нөлөөг бэхжүүлэн угсаа залгамжлах ёсыг сэргээн тогтоолгожээ. Харин монголчуудын хувьд Солонгост нөлөөлөн, хяналтаа тогтоож, шахалт үзүүлэх зэрэг хоёр талын ашиг сонирхол нийцсэн хэрэг болсон гэж үзэж болох юм. Ер нь монголчууд төрийн ураг барилдсан болоод ч тэрүү солонгосчуудад бусад хараат улсуудаас илүү онцгой итгэл үзүүлж байсныг хэлэх хэрэгтэй. Алс дорнодын түүхэнд Солонгосын хойг ямагт стратегийн чухал ач холбогдолтой байсан билээ. Учир нь Хятадыг эзэлсэн аливаа улс гүрэн өөрийн нөлөөг бататган тэлэхийг санаархаж, Манжуур болон Солонгосыг эзлэн Японы аралд хүрэх замыг эрэлхийлдэг байсан юм. Солонгосын хамгийн урд өнцөгт байрлах цэгээс Японы эрэг хүртэл 100 орчим миль (160 орчим км) зайтай бөгөөд энэхүү усан зурвас нь олон зууны турш Японыг аливаа халдлагаас хамгаалсаар иржээ.

Хубилай хаанаас Азийн улсууд руу хийсэн дайныг их төлөв монголчуудын түрэмгий шинжээс болсон, аль эсвэл монголчууд чанад орших улс орныг сонирхсондоо ч гэдэг юмуу, алт эрдэнэс, шүр сувданд шунасанаас ч гэдэг юмуу, аль эсвэл тохиолдлын чанараас үүдэж үүсгэсэн гэвэл ихээхэн учир дутмаг тайлбар болох бизээ. Монголчуудын явуулсан аливаа дайны шинж чанарыг нягтлан харахдаа түүний шалтаг, шалтгааныг анхааран учир холбогдлыг нарийн задлан үзэх нь асуудалд бодитой хандахад чухал хүчин зүйлүүдийн нэг болох билээ.

Дэлхийн түүхэнд монголчуудын гүйцэтгэсэн үүрэг ялангуяа байлдан дагууллын талаарх янз бүрийн үзэл байдаг хэдий ч Монгол үндэстний хувьд авч үзэх юм бол чухам тэр үед л монголчууд дэлхийн ихэнх улсуудыг өөрийн хүчирхэг, нэгдсэн захиргаанд оруулан захирч байснаас харахад үнэхээрийн хүчирхэг, суу билэгт, дайчин ард түмэн

байжээ хэмээн бахархах сэтгэл төрнөм. Учир нь дэлхийн түүхийн бүхий л үеүдэд аливаа хүчирхэг улс, тэдний хаадууд том, жижиг улсуудыг өөрийн захиргаанд оруулан захирдаг байсан хэдий ч Чингэс хаан болон түүнийг залгамжлагчдынхтай харьцуулах юм бол газар нутаг, хүн ам болоод оршин тогтносон хугацаа, далайцын хувьд багаахан байсан гэж хэлж болох юм.

Судлаач Х.Шагдар “Монголчуудын аян дайн, цэргийн урлагийн түүх” (XIII зуун) номондоо дайсагналцах үндэс, дайн дэгдэх шалтгаан, түүний шинж чанарыг өгүүлээд дайсагналцах таван шинжийг тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Элч төлөөлөгчдийг доромжлох, алах;
2. Найрамдлын гэрээ зөрчих;
3. Дайсан оронтой эвсэл болох;
4. Зугтсан дайсныг орогнуулах;
5. Монголын вассал, эзэмшлийн газар нутагт халдах (1: 606) зэрэг нь дайныг эхлүүлэх, үргэлжлүүлэх шалтгааныг ургуулдаг гэсэнтэй санал нэг байна.

Дундад зууны үед ч, өнөөгийн дэлхий дахинд ч дайсагналын таван шинжийн аль нэг илрэхэд тухайн орон өөрийгөө хамгаалах арга хэмжээ авдаг нь тогтсон хэм хэмжээ билээ. Ер нь XIII зууны үеийн их аян дайнуудыг харахад улс орныхоо аюулгүй байдлыг ханган бататгах, дэлхийн бодлогод нөлөөлөхүйц газар орныг өөртөө нэгтгэн захирч, худалдаа эдийн засгийн чөлөөт бодлого явуулахад чиглэгдэж байлаа. Элч илгээх, солилцох явдал нь гадаад харилцааны чухал ухагдахуун бөгөөд XIII зуунд Ази, Европ, Африкийн 19 оронд Их Монгол улс ба Их Юан гүрний элчийг алж, хорьж, доромжлон гутаасан ба 12 оронд багаар бодоход Монголын 758 элч алагджээ (2: 712). Үүнээс харахад дипломат ёс журам ноцтой зөрчигдөж үндэсний аюулгүй байдалд санаатай аюул учруулсан учраас эдгээр улсууд руу гарцаагүй дайрч ял асуухаас өөр арга байгаагүй юм.

Дипломат үйл ажиллагаа нь тухайн орны гадаад бодлогыг хэрэгжүүлэх гол хэрэглүүр, улс үндэстний эрх ашгийг хилийн чанадад хамгаалах зорилгыг агуулсан өргөн хүрээтэй ажиллагаа байдаг. Төрт улсууд оршин тогтнох болсноор дипломат ёс журам улам боловсронгуй болон хөгжиж XIII зуун гэхэд улам төгөлдөржөөд байлаа. XIII зуун гэхэд элчин харилцаа улам өргөжин “Төрийн алтан аргамж” гадаад бодлогын нэн чухал хэсэг хэмээн анхааран үзэж байлаа. Элчийг доромжлох, алах явдлыг үл уучилж, шууд дайн тулаан эхэлдэг уламжлал бараг ихэнх улсуудад байсан юм. Тийм тогтсон жишгийг монголчууд ч дагаж байлаа.

Хубилай хаанаас Азийн улсууд руу хийсэн цэрэг дайны томоохон ажиллагаанаас ихээхэн анхаарал татдаг зүйл бол Япон руу хийсэн хоёр удаагийн далайн дайн юм. Энэ нь Эзэнт улсын цэргийн түүхэнд гарсан гунигтай бөгөөд учир битүүлэг ялагдал болсноороо ихээхэн анхаарал татдаг юм.

Монголчууд Солонгосыг эрхшээлдээ оруулсан нь Японы арлуудыг буулгаж авах боломжийг тэд нарт нээн өгсөн юм. Харин далай тэнгист аялах талаар туршлагагүй тул тэд солонгосчуудын мэдлэг туршлагыг ашиглахаас өөр арга үгүй байв. Солонгосчуудын хувьд сайн дураараа хамтраагүй ч гэлээ Хубилай хааны зүгээс тавьсан шаардлагыг няцаан эсэргүүцэх чадал тэдэнд даан ч байгаагүй юм.

Хубилай хааны Монголын цэргийн урлагт оруулсан нэг шинэ зүйл бол усан флотыг байгуулсан явдал юм. Энэ нь монголчуудын хувьд цоо шинэ зүйл байсан төдийгүй хүчирхэг улсын цэрэгт байх зайлшгүй төрөл анги учраас онцгой анхаарч байсан юм. Хубилай хаан 1265 оны хаврын тэргүүн сард Тун Вэньбинийг Хэнань мужийн дэд жанжнаар томилсны дараагаар “усанд хатгалдах 500 онгоц хэлхэж, цэрэгтээ усанд хатгалдах арга сургах” (3:516) зарлиг буулгажээ. Үүгээр Монголын Их Эзэнт гүрэний усан цэргийн флотын үүсэл тавигдсан гэж үзэж болох юм. Энэ нь улс орноо төвшитгэн хамгаалах, цаашилбал далайгаар дамжин шинэ шинэ газар оронд хүрэх, нээх зорилготой байснаас бус түрэмгийлэн эзлэх гэхээсээ илүү монголчуудын хувьд сонин содон зүйл байсан бизээ гэж бодогдном.

Япончууд монголчуудын хүч түрэн наашилж буйг их сайн мэдэж байлаа. Ялангуяа Цэргийн зөвлөл буюу бакүфү нь байдал аюултай болсныг сайн ойлгож байсан ба тулгараад буй нөхцөл байдлын талаар Солонгост байсан өөрийн тагнуулуудаар дамжуулан тодорхой мэдээлэлтэй байжээ. Түүнчлэн монголчуудад шуудхан захирагддаггүй бөгөөд тухайн үедээ япончуудад талтай солонгос иргэд шаардлагатай мэдээллийг тэдэнд илгээдэг байжээ. Хубилай хааныг Япон улсыг эзлэн авахыг санаархаж дайн хийсэн гэж зарим судлаачид үздэг ч үнэндээ харилцаа тогтоохыг л чухалчилж байснаас бус дайтах сонирхол байгаагүйг түүний хэд хэдэн удаа элч томилон захидал илгээж байснаас харж болох юм.

1266 онд Хубилай хаан Цэргийн яамны дэд сайд Хэйди, Ёслолын яамны дэд сайд Инхун хэмээх хоёр элчийг Сон Кун Би, Ким Чан хэмээх хоёр Солонгос түшмэд, Сон Гүнбигаар газарчлуулан солонгос цэргүүдийн хамтаар Япон руу илгээсэн байдаг. Үүнээс харахад Хубилай хаан Японтой харилцаа тогтооход хятадуудаас илүү солонгосуудыг

найдвартайд үзэж, итгэл үзүүлсэн бололтой. Тэд нар 1266 оны 11-р сарын 25-нд Солонгосын нийслэлд ирээд 11-р сарын 28-нд Көжэ арал хүрээд далайн салхи шуургатай байсан тул замаасаа буцжээ (4: 58). Уг захидал дотор “бага орон их гүрний иргэн улс байх ёстой” тул Япон нь Юан улсын түшмэг улс болох хэрэгтэй бөгөөд үүнийг үл зөвшөөрвөл дайн хийх болно гэсэн утгатай зүйл байжээ (5:316). Хубилай хааны захидлын хамт Солонгосын вангаас Японы хаанд Монгол, Япон хоёрыг зохилдож найрамдахыг уриалан, Монголын хаанд элч илгээн, ертөнцийн хааны мэндий нь мэдэхийг зөвлөжээ (6-45). Элч нар далайн шуурганаас болоод Япон руу явж чадаагүй байдаг. Үүнийг гэрчлэх Солонгосын вангийн айлтгал бичээсийг доктор Б.Сумъяабаатар “Туулин улсын судар”-аас эх хэлнээ орчуулан судалгааны эргэлтэнд оруулсан юм. “Өчүүхэн улс (Солонгос улсыг хэлжээ Д.Д) Эрхимийг ширээнээ заларснаас янагш, аугаа ивээлд багтаж, гучаад жилийн дайн дажны дараа сая л нэг амьсгаа авч, дөнгөн данган амь зууж байнам. Богдын хишиг тэнгэр мэт агуу аж. Ачийг хариулахаа андгарланам. Тэнгэр хийгээд наран дээрээс халиаж буй цагт, чадах зүйлээ хэрхэн огоорч, худал хэлэх билээ” (7-61) гэжээ. Ийнхүү элч нарын амжилтгүй оролдлого нь дан далайн шуурганаас ч болоогүй солонгос элч нарын үнэнч сэтгэл дутсан болохыг Хубилай хаан гадарлаж байсан тул тааламжтай хандаагүй нь лав бөгөөд дараагийн элчийг яаралтай явуулахыг тушаажээ. 1268 онд Хубилай хаанаас хоёр дахь удаагаа мөн л Хэйди, Инхун нарыг элчээр томилон явуулсан байдаг. Тэдний авч явсан захидалд: “...Япон нь улс нээснээсээ янагш Дундад улстай үе үе арилжаа хийдэг байсан атлаа намайг сууринаас сууснаас хойш нэг ч удаа элч зарж ирүүлэн эетэн найрамтая хэмээсэнгүй. Вант улс хараахан учир мэдэхгүй байгаа бололтой тул тусхайлан элчид бичиг өвөрлүүлэн илгээж, миний санааг сайтар сэнхрэн ухтугай хэмээв. Өдгөөгөөс эхлэн харилцан ирж очиж, амар мэндээ эрэлцэн, сайнаар эетэн найрамтвасаас зохис. Богд хүмүүн дөрвөн далайг нэгэн хотол гэрт нэгтгээ хэмээх бөгөөд харилцан ирж очиж, сайнаар эс эетэн найрамдах аваас юуных нь нэгэн гэр бүлийн зүй орших билээ. *Эетэх цэрэглэхийн алийг сонгохоо Ван сайтар тунгаатугай. Тийн мэдтүгэй*”. Энэхүү захидлын хятад эхийн хуулбарыг Монгол улсын Их хурлын дарга С. Төмөр-Очирыг Япон улсад айлчлах үед Тоодайжи сүмийн хамба лам бэлэглэсэн ба одоо үндэсний түүхийн музейд хадгалагдаж байна.

Хубилай хаанаас Японтой харилцахдаа хожим нь дайны түшиц газар болгохдоо ч Солонгосоор дамжуулж байсан нь хэд хэдэн учир шалтгаантай билээ. Юуны өмнө Солонгос нь Японтой ойр дөт, эртний харилцаатай байсан, Японыг бусдаас илүү сайн

мэддэг, мөн монголчуудын үгийг дуулгавартай дагадаг зэргийг чухалчилсан ба ямар ч тохиолдолд Өмнөд Сүн улсынхаас илүү итгэж байсан гэж хэлж болох юм.

Японы хаан Камэяма ордоныхонтой зөвлөлдөөд Монголын хаанд ямар ч хариу илгээхгүйгээр тогтсон ба монгол элч нар даруй хагас жил илүү хүлээгээд ямар ч үр дүнгүй буцсан байдаг. Ийнхүү багагүй цаг хугацаа алдсанд хилэгнэсэн Хубилай дараагийн элч нарыг илгээсэн нь 1268 оны эхээр Дазайфү-д хүрч, өмнөх элчүүдийн дамжуулах ёстой байсан хааны захидлыг Дазайфү-дахь “Chinzei Bugyo” буюу “Баруун бүсийн батлан хамгаалахын комиссар” цолтой төлөөлөгчид гардуулан өөрийн Засгийн газарт хүргүүлэхийг хүссэн байна. Дазайфү буюу Кюүшю дэх засгийн газрын төлөөний газар нь Кюүшү, Ики, Цушима арлуудыг захиран гадны довтолгооноос хамгаалах үүрэгтэй бөгөөд тэнд Цэргийн зөвлөлийг төлөөлөн суух Баруун бүсийн батлан хамгаалахын комиссарын төв штаб, түүний удирдлага доор байдаг байнгын цэргийн хүчин байрладаг байв. Дазайфу захидлыг яаралтай шуудангаар Камакүра-руу илгээсэн ба Цэргийн зөвлөл судалж үзсэний дараа Киото дахь хааны ордонд хүргүүлсэн байна. Цэргийн зөвлөл нь хааны ордон аливаа шийдвэр гаргах чадваргүйг сайн мэдэж байсан ч ёсыг даган Эзэн хаантай зөвлөлдөх нь зүйд нийцнэ хэмээн үзсэн тул захидлыг Киото руу илгээсэн явдал нь ёс төдий үйлдэл байжээ.

Хубилайн захидлын үг хэллэг Японы хааны ордонд хүчтэй түгшүүр дэгдээлээ. Нэн ялангуяа Япон эзэн хааныг “ван” хэмээн нэрлэсэн нь тэднийг ихэд хилэгнүүлжээ. Захидлыг хүлээн авсны дараа эзэн хаан асан Го Сага-гийн насны ойг тэмдэглэх төлөвлөгөөгөө ч цуцалсан байдаг. Эзэн хааны элчүүдийг тал тал тийш томоохон хийдүүд рүү илгээж бурхаддаа аюулт мэдээг хүргэхийг даалгаж, өдөр бүр эзэн хааны ордонд хуралдан цаашид хэрхэх тухай ярилцаж байв. Эцэст нь тодорхой шийдвэр гаргаж чадалгүй Хубилайд илгээх захидлын төслийг гарган Цэргийн зөвлөлд илгээн, түүнийг сайтар нягталсны дараа монгол элчүүдэд дамжуулахыг даалгав. Энэхүү хариу нь утга агуулгын хувьд тун ядмагхан үйлдсэн баримт байсан тул төдийлөн ойшоосонгүй.

Хэдийгээр Цэргийн зөвлөл байдал ноцтойг мэдэж байсан ч монголчуудын илгээсэн мэдэгдлийг үл тоон хариу өгөлгүйгээр элчүүдийг хоосон буцаажээ. Тэд их газар дээр өрнөж байсан үйл явдлын талаар, мөн солонгосчууд тэднийг бодвол илүү хүнд нөхцөлд орж үнэндээ тамирдсаныг сайн мэдэж байв. Учир нь тэр үед Солонгост Самбёлчугийн бослого гарч Юан болон Солонгосын эрх баригчдыг ихээхэн сандраагаад байсан юм.

Япончууд дээрх байдлыг сайн мэдэж байсны зэрэгцээ өөрсдийн далай тэнгисээр хүрээлэгдсэн арлын орны давуу тал, сайтар бэлтгэгдсэн дайчин анги (самурай) нартаа найдаж байв. Японы эрэгт газардсан элчүүдээр нь ямар нэгэн хариу илгээгээгүй, түүний шаардлагыг хүлээн аваагүй нь Хубилай хааны гүн дургүйцлийг хүргэж байсан хэдий ч дараа дараагийн элчийг илгээж байснаас харахад тэрбээр Япон руу довтлон дайн хийх санаа байгаагүй бололтой. Гагцхүү элчүүдээр хариу ирүүлээгүй, тэд нарыг дайжигнан тохуурхаж улмаар амь насыг нь хөнөөсөн явдал Хубилай хааныг бодлогоо өөрчлөн дайн хийхэд хүргэсэн юм.

Ийнхүү Хубилай хаан өөрийн элчийг 1266, 1268 оны 1-р сард элч илгээснээс хойш 1268 оны 12-р сар, 1269 оны 9-р сар, 1271 оны 9-р сар, 1272 оны 4-р сард тус тус Япон руу нийт 6 удаа элч удаа дараа илгээсэн нь тус орныг цус урсгалгүйгээр буулгаж авах оролдлого байсан билээ. Ингэхдээ элчүүдийг дагалдан яваа бараа бологсдын тоог ямагт нэмэгдүүлсээр байсан нь дайсандаа өөрийн сүр хүчийг үзүүлэн сүрдүүлэх гэсэн санааг агуулж байсан болов уу.

Анхны дайралт (1274 он)

1268 онд элчээр илгээсэн мэдэгдэл зорьсондоо хүрээгүйг мэдмэгц Хубилай Японыг хүчээр эзлэхээр сэтгэл шулуудсан байна. Тэрээр Солонгосын ванд усан онгоц бариулан ихээхэн хэмжээний цэрэг хуримтлуулахыг даалгажээ. Харин солонгосчуудын хувьд хүн хүч, хүнсээр дутагдаж байсан тул шаардлагыг цагт нь биелүүлж чадсангүй. 1273 онд хэдэн мянгаар тоологдох Монголын анхны цэрэг тус улсад хүрэлцэн ирэхэд хүнсээ орон нутгаас хангаж чадахгүйг ойлгон Хятадаас нөөц татахад хүрч байжээ. Бүтэн жил хоцорч, шинээр их хэмжээний талбайд тариа будаа тариалан нөөцөө нэмэгдүүлсний эцэст 1274 оны 11 дүгээр сард Монголын цэрэг далайд гарчээ. Өмнө нь ирээд байсан цэрэг дээр нэмж 15 мянган монгол болон хятад цэрэг, 8 мянган солонгос цэрэг аянд гарсан нь урдаа тавьсан том зорилтыг нь бодвол харьцангуй бага хүч байв. Дайралт хийх хөлгүүдийн багийг 7 мянга орчим солонгос усан цэрэг, мөн хятадын далайчид бүрдүүлж байсан ба нийт 300 том хөлөг онгоц, 400-500 жижиг завь аялалд гарчээ. Зарим түүхийн сурвалжуудад үүнээс илүү тоог заасан байдаг ч дээр өгүүлсэн тоог хамгийн ойр хэмээн таамагладаг ажээ.

Цүшима болон Ики арлыг элдэв саад түвэггүйгээр эзэлсэн ба эрэлхгээр дайтсан Японы цөөн тоотой цэргийг (гарнизон) бут цохижээ. Үүний дараа хөлөг онгоцууд

жолоогоо Кюшю арлын зүг залав. Нэг хэсэг нь Хирадо болон бусад цэгүүдэд цохилт өгөхөөр салсан бол үндсэн хүч нь 11 дүгээр сарын 18-ны өдөр Хоказаки буланд зангуугаа хаясан байна. Маргааш өдөр нь Хакада боомтод газардаж Дайзафү эргийн дагуу орших хэд хэдэн жижиг хот, тосгоныг эзэлсэн байна.

Цүшима арлыг эзэлсэн тухай мэдээ Дайзафүд тун хурдан хүрч Кюүшю арлын бүх мужийн дайчдад түгшүүрийн мэдээг хүргэжээ. Монголын цэрэг Хакадад ирэх өдөр зарлан дуудахыг Кюүшю арлын өнцөг бүрт хүрч дайчид яаралтай цугларсан байв. Тухайн үед тулгараад байсан гол саад бол Чикүго голыг гатлах явдал байсан тул яаралтай хөвөгч гүүр тавин барьж урд зүгт орших Сацума, Оосуми болон Хюүга мужуудаас умард зүг хөдөлсөн цэрэгт гол гатлах боломжийг нээн өгчээ.

11 сарын 19-нд Имазуд газардаж дараа өдрийн үүр цайх үеэр хөлөг онгоцны дэмжлэгтэйгээр Хаката хот руу дайрчээ. Гэгээ орсны дараа бага туслах Цүнэцүгүгийн удирдсан Кюүшү дахь бүх цэрэг дайралтыг сөрөхөөр яаравчлан очжээ. Тулаан тун ширүүн болсон байдаг. Монголчуудын тулааны баялаг туршлага нь тэдэнд давуу байдлыг олгож байсан бол япончуудын хувьд өөрийн зиндааны дайчинтай нэг нэгээр сөрөн байлддаг журам нь багагүй бэрхшээл авчирч байжээ.

Байлдаан хэрхэн явагдсан талаарх мэдээ бидэнд хомс байдаг бөгөөд япон сурвалжуудад бичсэнээр: "Юаны цэрэг гайхалтай эрчтэй нум сумтай. Хорт сум, дарь зэрэг японы цэрэгт байхгүй шинэ зэвсгийг хэрэглэж, цан, бөмбөрийн дохиогоор бөөнөөр давшин байлдаж байв...Тэдний цэрэг бөмбөрийн дохиогоор нэгэн зэрэг байлдахдаа гарамгай, хэдэн зуун хүн, нум сумаар мөндөр мэт харвадаг, сумны зэв нь хортой, өртсөн хүн, морь дорхноо үхдэг. Бөөнөөрөө байлдаж сураагүй бидэнд хэцүү байлаа" (8-72-73) гэсэн байдаг. Үүнээс харахад энэ тулалдаан нилээд ширүүн болсон төдийгүй байлдааны тактик, зэвсэглэл болон байлдах аргаараа ч монголчууд илүү байсан бололтой.

Японы газар нутаг дээр томоохон хэмжээний тулаан болж байснаас хойш даруй 50 жил өнгөрсөн байжээ. Тэр нь 1221 оны Го Тоба-гын бослого байлаа. Иймд монголчуудыг дайрах үед цэргийн ихээхэн хүчийг дайны талбарт удирдан зохион байгуулах чадвартай Япон жанжин бараг үгүй байсан гэхэд болох юм.

Мөн түүнчлэн монголчууд холын зайнд үр дүнтэй аварга нум сум, хүнд сум болон шатдаг материалыг шидэх төхөөрөмжөөр зэвсэглэсэн байсан нь бас нэг давуу байдлыг олгож байлаа. Энэ бүхний эсрэг япончуудын үзүүлсэн эсэргүүцэл нь өчүүхэн байсан ба зөвхөн өөрсдийн эр зоригороо л тэсэж байжээ.

Шөнө дунд япончууд ухарсаар Мизуки дэх эртний шороон бэхлэлтний ард нуугдаж амжжээ. Дараа өдрийн байдлыг таамаглахад тун бүрхэг дүр зураг харагдахаар байлаа. Учир нь төв болон зүүн мужуудаас нэмэлт хүч иртэл Кюшү дэх цэрэг дангаараа байлдвал үндсэндээ үгүй болох аюул учраад байлаа. Харин Хакатад япончууд амжилтанд хүрч чадаагүй ч гэлээ бууж өгөх бодолгүй байлаа. Түр ч болов амсхийх хугацаа олдсон нь монголчуудыг цэргийн тооны давуугаар ялах боломжийг олгоод байсан ч хэрэг дээр байдал тэс өөрөөр эргэсэн юм.

Кюшүгийн эрчүүдийн аз болоход далайн шуурга дэгдэх шинж илэрч, үүнийг мэдэрсэн солонгос чиглүүлэгчид монгол жанжнуудад хөлөг онгоцон дээрээ хурдан сууж эргээс холдохыг анхааруулан ятгажээ. Хэрэв амжихгүй бол хөлөг онгоц шуурганд шахагдан хад, чулуу мөргөн сүйрч монгол цэргийн ухрах зам хаагдах байлаа. Нөгөөтэйгөөр энэхүү бороо шуургыг далимдуулан япончууд өөрсдийн сайн мэдэх нутаг дэвсгэр дээр шөнийн дайралт хийх магадлал их байсан нь бүүр ч их аюул учруулж болохыг мэдэж байлаа. Иймд монгол жанжингууд цэргүүдээ хөлөг онгоцондоо суух тушаал өгчээ. Гэхдээ хэрэг дээрээ шөнийн дайралт болсон талаарх мэдээг одоогоор хараахан олж үзээгүй байна.

Юаны цэрэг усан онгоцондоо суусныг Академич Ч.Далай “Монгол Японы дундат эртний үеийн түүхэн харилцааны тоймоос” өгүүлэлдээ: “Чингисийн монгол цэргийн уламжлалт дүрэм ёсоор шөнө байлдахгүй, заавал байрандаа эргэж ирж хононо, бусдын гэрт хонож айлын тух алдуулахгүй учиртай байж. Энэ нь далайн шуурганд өртөх нөхцлийг бүрдүүлж өгчээ ” (9-37) гэжээ. Гэвч нөгөө талаас нь авч үзэх юм бол Юаны цэрэг усан онгоцон дээрээ гарсан явдал нь юуны түрүүн өөрсдийн аюулгүй байдлаа хангах гэсэн хэрэг болов уу гэж бодогдоно. Ямар ч хүчтэй, туршлагатай байсан гэсэн шөнө дөлөөр шуурган дунд харийн газар нутаг дээр сайтар бэлтгэгдсэн цэргийн эсрэг дайтах гэдэг нь яавч амжилт авчрахгүйг сайтар мэдэж байсан бизээ. Тэгээд ч ойртож буй далайн шуурга нь хоол хүнс, зэр зэвсгийг нь тээсэн хөлөг онгоцнуудыг сүйрүүлбэл хүний газар цэргүүдээ бүүр ч их аюулд учруулж болзошгүйг Юаны жанжид сайн мэдэж байсан учраас яаралтай задгай тэнгист гарах тушаал өгсөн нь зөв шийдвэр болсон гэж бодогдном.

Монголчууд ухрахдаа Хаката болон эрэг дагуух тосгодыг галдан шатааж амжсанаас үзвэл Мизуки-д бүгсэн япон жанжид дайснаа таслан зогсоох оролдлого хийгээгүй боловуу. Мөн япон цэргүүд ядарч сульдсанаас гадна салхи шуурганд шөнийн

тулаан явуулах чадамжгүй байсан ч байж болох юм. Ямартаа ч тэдний аз дайрахад, үүр цайхад монгол цэргийн хөлөглөсөн сүүлийн хөлөг буланг орхин гарч байхыг тэд олж харчээ. Ямарч байсан нэг хөлөг онгоц хад мөргөн зогсож олон хөлөг далайн шуурганд өртөн живжээ. Зарим эх сурвалжийн мэдээгээр 200-аад хөлөг сүйрсэн гэдэг (10:444), харин солонгос эх сурвалжуудад довтолгоч тал энэ аяны үед 13000 хүнээ алдсан (11:76) тухай өгүүлсэн байдаг. Олон хүн, магадгүй дийлэнх олон нь далайд живсэн байх магадлалтай юм.

Ийнхүү энэ тулаан бүтэлгүйтсэн нь монголын цэргийн үлдсэн хэсэгт хүнд цохилт өгсөн нь маргаангүй билээ. Учир нь урьд өмнө болсон том тулаануудад ийм их хэмжээний хохирол амсаж байсан удаа байгаагүй юм.

Монголчуудын довтолгоон эхлэхийн өмнө япончууд ямар байдалтай байсан талаар хэдэн зүйлийг хэлье. Монголчуудын довтолгоон япончуудын хувьд гэнэтийн биш болохоор бэлтгэлээ базаагаад байсан хэдий ч тэд их айж түгшсээр байлаа. Ялангуяа Кюүшү монгол цэрэг Японы эрэгт газардсан тухай мэдээ Киото болон Камакурад сарын сүүлээр хүрсэн байдаг. Цэргийн зөвлөл нь мэдээж Монголын цэрэг Кюүшү-д байрлаж байсан Японы цэргээс тоо болон хүчээр давамгайлах вий гэдгээс үнэндээ айж байлаа. Тийм учраас 12 сарын 1-ний өдөр Кюүшү арал даяар зарлан дуудах бичиг тарааж цэрэг дайчдыг яаралтай цуглууж эхэлжээ. Уг бичигт харьяалал үл харгалзан гавъяа байгуулсан хүнд өндөр шан харамж өгнө хэмээн зар тараасан байдаг. Үүний зэрэгцээ бүх газар эзэмшигчид болон сүм хийдүүд нь батлан хамгаалах ажилд дайчлагдсан байдаг. Түүнчлэн гол арлын баруун хэсгийн хамгаалалтанд анхаарлаа хандуулж бүх цэргийн хуаранг бэхжүүлэх арга хэмжээ авч эхэлжээ. Гэвч цаг хугацаа бага, зай хол, дайчид идэвхтэй үйл ажиллагаанд бэлэн бус байсан тул үүнээс илүүг хийх боломж бага байсан бизээ.

Хааны ордны хувьд ялалт авчрахыг л гуйж бурхандаа залбирч, өвөг дээдсийнхээ бунханд элч илгээж ёс заншлын зан үйл үйлдэхээс өөрийг хийж чадахгүй байлаа. Юан улсын дайралт бүтэлгүй болсон тухай мэдээг тэд сонсоод өөрсдийнх нь үгийг сонссон бурхандаа талархал илэрхийлж мөргөлөө цааш нь үйлдсээр байжээ. Ийнхүү ямартаа ч нэг удаа япончууд аврагджээ. Харин Хубилай хаан бүтэлгүйтсэний бурууг зөвхөн далайн шуурганд өгч байсан ба үүнтэй хэн ч маргадаггүй байжээ.

Хоёр дахь дайралт (1281 он)

Хубилай хаан даруй элчийг дахин томилон 1275, 1279 онуудад Япон руу илгээх шийдвэр гаргасан байдаг. Хубилай хаан анхнаасаа элчээр илгээсэн захидлаа Японы ванд (King of Japan) хэмээн гарчиглаж байжээ. Японы хааныг Ин хэмээн дууддаг нь эзэн хаан (emperor) гэсэн утгатай ажээ. Үүнийг судлаачид янз бүрээр тайлбарладаг бөгөөд зарим нь Хубилай хаан Япон улсын хааныг “Эзэн хаан” хэмээн дууддагийг мэддэггүй байсан гэж бичсэн байдаг. Гэвч миний бодоход Хубилай хаан мэддэггүйгээсээ бус 4 зүг 8 зовхисын улсуудыг эзлэн өөрийн захиргаанд оруулсан “Далай их хаан” учраас зориуд тэгж бичсэн гэж үзэж байна. Тэрхүү захидалд Японы ванг даруй нийслэлд хүрэлцэн ирж хүндэтгэл үзүүлэхийг шаарджээ. Энэ үг цэргийн зөвлөлийг маш их сандраасан төдийгөө уур хилэнг нь бадрааж гарцаагүй ирэх ээлжит дайралтанд бэлтгэж эхлэхэд хүргэсэн юм.

Шинэ дайралтанд бэлтгэхийн тулд цэргийн зөвлөл нь улс орноо батлан хамгаалах урт хугацааны төлөвлөгөөг зохиожээ. 1275 онд Сүво, Аки болон Бинго муж Нагато мужийн хамтаар Нагато-гийн суваг орчмын дагуу газрыг хамгаалах тушаалыг хүлээн авчээ. Кюүшү-д Хаката зэрэг стратегийн ач холбогдол бүхий хэд хэдэн газарт хамгаалалтын цэгүүдийг шинээр байгуулжээ. Мөн мужуудаас цэргүүд ээлж ээлжээрээ ирж хуарангийн маягаар хамгаалалтанд заавал гарах дарааллыг тогтоон өгч цаашид аливаа зарлан дуудлагыг дуулгавартай хүлээн авдаг болгох талаар тодорхой арга хэмжээнүүдийг авчээ. Эхний дайралтын үед зарим вассалууд ямар нэгэн шалтгаар цугларалтанд хамрагдахаас зайлсхийж байсан бол энэ удаад үл зөшөөрсөн байдал гаргасан тохиолдолд түүнийг гэмт хэрэгтэн мэт үзэж хатуу шийтгэл үзүүлэх болгосон байна.

1275 оны эхээр Киото хотод эзэн хаан Камияма Ивашимизу сүмд эх орныхоо аюулгүй байдлын төлөө мөргөл хийжээ. Үүний хамтаар бусад томоохон сүмүүдэд элч нарыг илгээн бурхадаас гадны дайсны зүгээс ирэх аюулаас хамгаалахыг гуйхыг даалгажээ. Япон улс даяар үндэсний болон орон нутгийн удирдлагад хандсан бичгүүдийг илгээж монгол цэргийн устгасан Хахозаки сүмийг сэргээн босгох зарлигийг цэргийн зөвлөлд хүргүүлжээ. Үнэндээ энэ үед шинто шашинд итгэх итгэл урьд өмнө байгаагүйгээр өсөж бурхад болон өвөг дээдсийн баримталж байсан ёс заншил сэргэж онцгой их нэмэгдсэн.

Үнэндээ монголчууд дахин довтлох хүсэл эрмэлзэлтэй байсан боловч тэдэнд бэлтгэлээ хангахад багагүй цаг хугацаа шаардлагатай байсан нь япончуудад ихээхэн аз

завшаан болсон юм. Хубилай хаан умард Хятадын Сүн улсыг буулгаж авахын тулд ихээхэн хэмжээний цэрэг дайчлан явуулсан тухай, мөн Солонгос дахь нөхцөл байдлын талаар тэд сайн мэдэж байсан байх ёстой. Үнэндээ Солонгосын ард түмний аж байдал дээшилж 1274 оны ялагдлын үр дагавар арилахаас нааш солонгосчуудыг дайны зорилгоор ашиглах нь нэн бэрхшээлтэй байсан. Өмнөх жилийн ургацыг хэрэглээд дууссан, тухайн жилийн ургац бага гарсны улмаас солонгосчуудад өлсгөлөнгийн аюул тулгараад байлаа. Цөөн тооны талбайд хөгшид болон хүүхэд багачуудын хүчээр тариалалт хийгдсэн бөгөөд ажлын чадамж бүхий насанд хүрэгсэд хөлөг онгоц барих ажил буюу дайн тулаанд дайчлагдсан байжээ. Иймд Солонгосын ван Их хаанд хандан Японыг эзлэх төлөвлөгөөгөө өөрчлөхийг ятгаж байлаа. Гэвч Хубилай хаан өөрийн бодлоосоо няцалгүй 1275 оны 5-р сард өөрийн элч нарыг Япон руу илгээсэн юм. Энэ удаа Нагато мужийн Мүроцу-д газардсан боловч орон нутгийн эрх баригчид тэднийг нийслэл Камакура-д аваачсан байдаг. Элч нар зорилгоо биелүүлэн нийслэлд хүрч хоёр орон найрсаг харилцаа тогтоохын чухлыг тайлбарласан хэдий ч Японы засгийн газрыг толгойлогч Хоожёо Токимүнэ өмнөхтэй адил байр суурьтай байхаар шийдэж элчүүдийг 10 сард цаазалсан байдаг. Хоожёо Токимүнэгийн энэ шийдвэр бол маш бодлогогүй, ёсгүй бүдүүлэг зүйл байсан юм. Хэдийгээр өмнөх элчүүдийг ч ялгаагүй цаазалж байсан хэдий ч тэд нар нийслэлд хүрч байгаагүй учраас захидал хүрэх эзэндээ хүрэлгүйгээр завсардан эндэгдэж, өөрчлөгдсөн байж болох гэж үзэж болох хэдий ч энэ удаагийн цаазлах шийдвэр бол Японы засгийн газрын шийдвэр байсан юм. Хубилай хааны элч нараас Японы нийслэл хүрсэн нь гагцхүү 1275 оны элч нар бөгөөд бусад нь ихэвчлэн Кюүшү, Цүшимад очиж захидлыг тэд нар нийслэлд хүргэлгүй япон хүмүүс авч явдаг байсан юм.

Юаны элч нарыг цаазалсан явдал нь монголчуудын хийж болзошгүй дайралтаас эмээлгүй, Японы дайчид сайтар төлөвлөсөн хүчтэй эсэргүүцлээр угтахад бэлэн байгаагаа илэрхийлсэн шууд өдөөн хатгалаг гэж үзэж болох юм.

Цэргийн зөвлөл нь баруун зүгийн батлан хамгаалах чадварыг дээшлүүлэхэд боломжтой бүхнээ зориулж байв. Баруун зүгийн хэсгүүдийг харуул хамгаалалтын байнгын үүргээс чөлөөлөхийн хамт хааны ордны дээдэс болон феодалууд нь хувийн хэмнэлтийн горимыг гаргаж хэмнэсэн зүйлийг батлан хамгаалахад зориулах болжээ.

Тэдний хийсэн хамгийн том мэдэгдэхүйц зүйл бол Шига-гийн үзүүрээс Хоказаки булан, Имазу хүртэлх эрэг дагуу газруудад чулуун хана босгосон явдал юм. Гол зорилго нь Юаны цэргийг эх газарт газардахаас хамгаалах, газардлаа ч гэсэн хоорондоо нэгдэх

боломжгүй болгох зорилготой байв. Тэд нар довтлогч тал урт ханыг хараад сүрдээд өөр гарц хайх гэж цаг алдана гэж тооцож байлаа. Цэргийн зөвлөлийн үүрэг, зорилго хэцүү байлаа. Учир нь нэг талаар өөрийнхөө удирдах чадварыг шалгаад зогсохгүй нөгөө талаар дайчин ангийг захиран чиглүүлэх үүргээ биелүүлж буй эсэхээ хянах бололцоог олгох байв. Япончуудын аз болоход Монгол цэргийн довтолгоо 1281 он хүртэл хойшилж тэд нарыг чулуун ханаа барьж дуусгах, цэргийн хүчээ бэхжүүлэх бололцоог олгосон юм.

Энэ үед солонгосчууд тун хөөрхийлэлтэй байдалд байсныг хэлэх хэрэгтэй. Хубилай хааны зүгээс Япон руу хийх дайралтанд бэлтгэх шаардлага тавин байнга шахаж байсан байна. 1279 онд Хубилай хаанаас Солонгосын ванд 1000 байлдааны хөлөг онгоц бүхий тэнгисийн шинэ флотыг байгуулж бие бүрэлдэхүүнийг бэлтгэх, мөн 20000 дайчин бүхий хуурай газрын цэргийг бүрэлдүүлэх хатуу зарлиг буулгажээ. Энэ үед 50000 хүнтэй Монголын цэрэг Солонгосын зүүн эрэгт хүрч завинуудаа хүлээж байх ёстой байлаа. Энэ нь 1274 оныхтой харьцуулах юм бол даруй 2 дахин их хүчийг бэлтгээд байжээ. Мөн Хубилай хаанаас “Японыг шийтгэх алба”-ыг байгуулсан нь Японыг буулгах хүртэлх бүх ажлыг зохицуулах үүрэгтэй байжээ. Өмнөд Хятадыг буулган авснаар тэдний хөлөг онгоцуудыг өөрийн мэдэлд оруулсан ба тэдгээрийг Японы эсрэг хийх үйл ажиллагаанд ашиглажээ. Хубилайн мэдэлд 100000 хүн буюу Сүн улсын бараг бүх цэрэг багтах боломжтой том, жижиг хөлөг онгоцууд очсон байсан юм. Энэ үед Солонгосын ван Хубилай хаанд тал засах зорилгоор Чанган-нор буюу Цинан-д өөрийн биеэр ирж хаанд тусламжаа санал болгожээ. Тэрбээр хэлэхдээ энэхүү аянд Солонгос нь гол үүргийг гүйцэтгэх ёстойг тэмдэглээд 900 хөлөг онгоц, 15000 далайчин, 10000 дайчид мөн их хэмжээний хоол хүнс, зэр зэвсэг, тоноглолыг санал болгожээ. Үүний хамтаар ерөнхий командлалыг өөрөө авах эсвэл шийтгэх албыг удирдах хүсэлтэй байгаагаа хэлсэн байна. 15000 далайчин 300 хөлөг онгоцонд хуваагдаж үлдсэн хөлөг онгоцуудад хятад далайчдыг томилон монгол цэргүүдээр дүүргэнэ гэсэн төлөвлөгөөтэй байв. Солонгосын ван өөрийн байр суурийг Хубилай хаанд шуудхан ойлгуулахын хамтаар нэгэн болзол тавьсан нь Солонгосын адмирал Ким-ыг тэнгисийн флотыг бүхэлд нь захируулах явдал байлаа. Хубилай дургуйцаагүй ч энэ аянд илүү их хүчийг дайчлах шаарлагатайг хэлж байжээ. 1281 оны эх сурвалжуудад бичихдээ: “өнгөрсөн оны 8 сард Солонгосын ван Чанган- норт ирж түүнийг их хаан хүлээн авч уулзсан. Ван болон жанжнуудтай зөвлөлдсөний эцэст дайралтын төлөвлөгөөг баталжээ. 40000 Монгол, Солонгос, Умард Хятадын цэргийг

тээсэн цэргийн хөлөг онгоцууд Ики арлын ойролцоо Өмнөд Хятдын 100000 цэрэг тээсэн флоттой нийлж цаашид Японыг бут цохихоор хөдөлнө” гэсэн байдаг (12:449).

Дайралтыг эхлүүлэх зарлигийг Хубилай хаан шинэ оны буюу 1281 оны 4 дэх өдөр буулгажээ. Солонгосын флот 1281 оны хавар гэхэд далайд гарах бэлтгэлээ хангасан байлаа. Харин хэтэрхий том Хятадын флот нь багаа бүрдүүлэх, хүнсний нөөцийг бэлтгэхэд багагүй бэрхшээл тулгарсан тул хоцорч байлаа. Солонгосын жанжид монголчуудын шахалтаар хүчээ сорьж Цүшима арал руу дайрч үзжээ. Энэ арал нь 1274 оныг бодвол илүү сайн бэхлэгдсэн байсан тул Монголын цэрэг ширүүн эсэргүүцэлтэй тулгаран Масанпо дахь байрлалдаа буцсан байдаг. Харин тэнд очсон хойно нь өвчин дэгдсэний улмаас дахин дайрах санаагаа түр орхижээ. Үл мэдэгдэх шалтгааны улмаас хөлөг онгоцнууд зуны эхэн сар хүртэл далайд гараагүй байдаг. Энэ нь өвчин дэгдсэний улмаас уу, аль эсвэл араас ирэх хүчийг хүлээснээс болсон уу гэдэг нь одоо ч тодорхой бус байгаа юм.

Энэ үед Хятадын манлайлагч флотыхон түүний тэргүүн хэсэг Ики аралд өмнө зүгээс ойртож байгааг мэдээлжээ. 6-р сарын 10-ны өдөр Солонгосын флот Хятадын флотын гол хүч ирэхийг хүлээлгүй Ики арлыг эзлэн авч улмаар Чикүзэн-ий эргийн зүг жолоогоо залсан байна. 6 сарын 23-ны өдөр тэд Мүнаката болон Хакозаки булан дахь хэд хэдэн цэгт газардаж стратегийн ач холбогдол бүхий Шига-ийн үзүүрийг эзлэн авчээ.

Үлэмж хэмжээний Монголын цэрэг Хизен мужийн хойд талд газардан тойрох маневр хийсэн тохиолдолд хананы цаана байсан япончуудад хүрэх зам нээлттэй болох байв. Энэ сул талыг Монголын жанжид сайн мэдэж байсан тул цаг алдалгүй Хятадын флотыг зүүн зүгээс дайралтанд оруулан Хирадо болон бусад цэгүүдийг эзлэн авч тэнд их хэмжээний хятад цэрэг газарджээ. Энэ тухай нарийн мэдээлэл бидэнд үлдээгүй ч япончуудын бэлтгэл тун сайн байсан ба зарим тохиолдолд Кюшү-гийн дайчид хориглох байр сууринаас сөрөг дайралтанд орж монгол цэргийн дайралтанд жигд эсэргүүцэл үзүүлж байжээ. Мөн үүний зэрэгцээ шуурхай цохилт өгөхөд зориулагдсан жижиг хөлгүүд Хятадын том овортой цэргийн хөлөг болон тээврийн хөлгүүдийг таслан устгахад ихээхэн өөрөг гүйцэтгэсэн. Япончууд энэхүү ширүүн эсэргүүцлийг хир удаан үргэлжилж үлэмж хүчний эсрэг хэдий удаан үргэлжлэх нь тодорхой бус байлаа. Ямарч байсан 6 сарын 23-8 сарын 14-ний хооронд Мүнаката-гаас Хизэн муж хүртэл урт бэхлэлтийг баттай хамгаалж чаджээ. Хаана нэгэн газар эвдрэл гарахад тэр дор нь засаж монголчуудын довтолгооныг нэвтрүүлэхгүй байжээ. Харин Хятадын цэргийн хувьд тулаанд орох сонирхол тун бага

төдийгүй идэвхгүй байжээ. Учир нь саяхан болтол сөргөлдөн тулалдаж байсан, өнөөдөр эзэн нь болсон монголчуудын төлөө үнэнчээр зүтгэсэн гэж үзэх нь эргэлзээтэй юм.

Гэсэн хэдий ч энэ бүхэнд эцсийн цэг тавьсан нь хэн нэгний байлдааны ур чадвар бус өөр хүчин зүйл гарсан юм. Ер нь 8 сар гэдэг нь Японыг хүрээлэн буй далай, тэнгист ширүүн хар салхийг авчирдаг үе юм. Энэ нь нэн ялангуяа Японы арлын баруун урд хэсэгт ихээр мэдрэгддэг ба 1281 онд маш хүчтэй далайн шуурга дэгдэж Кюүшү-д болж байсан ширүүн тулааныг зогсооход хүргэсэн. Энэ шуурга нь дайсны флотыг үхэлд хүргэн япончуудыг аварсан тул Японы түүхэнд Камиказэ буюу бурханы салхи хэмээн нэрлэгддэг. Энэ үйл явдал нь 8 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд болж өнгөрчээ.

Монголын цэргийн хохирол хэдий хэмжээнд хүрсэн нь одоо ч тодорхой бус байдаг. Хохирлын талаар япон, хятад, солонгос сурвалж, ном зохиолуудад янз бүрээр тэмдэглэгдсэн байдаг юм. Тухайлбал: “Юан ши”-д 100000 хүнээс 10 хүрэхгүй (3-8 хүн) хүн үлдэж хоцорсон... “Юан төрийн түүх” зохиолд 140000 их цэргээс тавны нэг нь буцаж ирсэн, Солонгосын түүхэнд Солонгосоос явсан 40000 цэргээс 19397 хүн буцаж ирсэн” (13:43) гэсэн байдаг. Юаны цэргийн бүрэлдэхүүнд орсон улсуудын сурвалжийн мэдээ өөр өөр байдгаас амь үрэгдсэн болон буцаж ирэгсдийн тоо тодорхой гаргахад хүндрэл учирч байгаа ч 10 хүрэхгүй хүн буцаж ирсэн гэдэг нь тун эргэлзээтэй мэт санагдана. Нөгөөтэйгөөр солонгос, хятадуудын аль аль нь монголчуудын захиргаанд байсан учраас зориуд хохирлыг ихэсгэж сэтгэл зүйн цохилт өгөх, мөн Хубилайн дараагийн дайралтыг тасалдуулах давхар зорилготой байсан ч байж болох юм. Тийм санаа ялангуяа Солонгосын зүгээс нилээд гарч байлаа. Учир нь хөлөг онгоц бэлдэх, цэргүүдийн хүнс хоолны хангалт зэрэг асуудлууд дан тэдэнд даалгагдаж байсан юм.

Ихэнх баримтуудаас харахад Солонгосын хөлөг онгоцууд ирж буй аюулыг мэдрэн далайн шуурга оргилдоо хүрэхээс өмнө эргээс холдож чадсан гэж үздэг. Гэсэн хэдий ч тээж явсан монгол, солонгос нийт цэргийн гуравны нэг нь үрэгдсэн гэдэг. Харин Хятадаас ирсэн флот гол төлөв Хизэн дэх Имари буланд дайтаж байсан тул эрэг хавийн далайн шуурга ид хүчтэй байхтай таарсан байдаг. Шуургаас зугтсан хөлөг онгоцууд задгай тэнгист гарахаар яаравчилж байсан ч далайн татлаганд болон хүчтэй салхинд шахагдан аргагүй байдалд орж боомтын хоолойд гацжээ. Задгай тэнгист гарч амжсан хөлгүүдээс цөөнгүйг, магадгүй олонхыг нь далайн шуурга авч одсон гэдэг. Нийт хохирол маш их байсан нь гарцаагүй. Хятадын хөлөг онгоцуудад 100000 хүртэлх хүн тээж явсан ба тэдний талаас илүү хувь нь хөлөг онгоцонд яаран суух үед алагдсан ба усанд живсэн

байх магадлалтай. Хятадын тэнгисийн хүчний гол хэсэг Имари буланд орж ирсний дараахан Хизэн-ий эрэг дагуух хэд хэдэн цэгт цэргийн хүчээ төвлөрүүлж, үлэмж хүчээр булангийн амсар дээр байрлах Такашима арлыг эзэлсэн байна. Эдгээр цэргүүдийн ихэнх нь эргээд хөлөг онгоцондоо хүрч чадаагүй бөгөөд шуурганы хүч буурахаас өмнө Кюүшюгийн цэрэг энд тэндээс цохилт өгч байсан тул олон цэрэг алагдаж, зарим нь олзлогдсон байх магадлал өндөр юм.

Живсэн хөлөг онгоцны тоог тодорхой гаргах боломжгүй билээ. Учир нь түүхийн ихэнх сурвалжуудад живсэн хөлөг онгоцуудыг том жижгээр нь ялгаагүй байдаг. Хятадын өмнөд хэсгээс дайчилсан хөлөг онгоцны тоо 3500-д хүрч байсан гэх ч энэ тоонд жижиг хөлөг онгоц, завьнуудыг хамтад нь багтаасан болов уу гэж бодогдоно. Мөн жинхэнэ том оврын байлдааны хөлөг онгоцны тоо дээрх тооны 1/3-ээс хэтрэхгүй байсан гэх байр суурь ч байдаг.

Юаны цэргийн 2 удаагийн довтолгоон амжилтгүй болсон шалтгааныг далайн шуурга, эсвэл жанжид нь хоорондоо хагаралтай байсан, мөн байлдааны чиглэлийг буруу сонгосон, хүчээ төвлөрүүлээгүй, монгол цэргийн байлдааны арга тактикийн гадуур явсан зэрэг олон хүчин зүйлээр тайлбарладаг. Гэвч эдгээр зүйлүүдээс илүү солонгосчуудад хэт итгэсэн байдал сөргөөр нөлөөлсөн ч байж болох юм. Солонгосчууд монголчуудыг бодвол далайн туршлага ихтэй ч Юаны цэргийг ид далайн шуурга болдог 8 сард далайд авч гарсан нь ихээхэн анхаарал татаж байгаа юм. Далайн их шуурганы улирлын талаар монголчууд мэдэхгүй байж болох ч солонгосчууд мэдээгүй, аль эсвэл “мартсан” байна гэж баймааргүй санагдана.

Мөн солонгосчууд монголчуудтай төрийн худ ургийн харилцаатай хэдий ч Хубилай хааны зүгээс ирэх цэрэг байлдааны бэлтгэлийг хангахтай холбоотой хөлөг онгоц хийх, цэргийн хүнс хоолыг базаах гээд аль хүндрэлтэй асуудлуудыг гол төлөв тэдний нуруун дээр ирдэг тул энэ ачаа дарамтыг зайлуулахын тулд ихээхэн хохирлыг зориуд амсаад дахин Япон руу довтолох Хубилай хааны хүслийг тасалдуулах гэсэн оролдого ч байсныг ч үгүйсгэх аргагүй билээ.

Энэ мэтчилэн Хубилай хаанаас Япон руу явуулсан 2 удаагийн довтолгоо, бэлтгэл, явц, түүний амжилтгүй болсон шалтгаан, хохирол болон хөлөг онгоцнуудаас чухам хэд нь буцаж ирсэн талаар одоо болтол тодорхой зүйл алга байдаг бөгөөд энэ талаарх судалгааг улам нарийвчлан хийх шаардлагатай байгаа юм.

Хубилай хааны түүхэнд гүйцэтгэсэн үүргийг тодруулахад гаргахад их олон хүчин зүйл шалтгаалах бөгөөд гадаад идэвхтэй бодлого явуулсан байдал ч нөлөөлөх нь гарцаагүй юм. Үнэхээр Эзэнт гүрний хил хязгаарийг дорно зүг хэдэн мянган бээрээр урагшлуулж, нэгэн гүрний захиргаанд оруулан Өрнө, Дорныг ойртуулж өнөөгийн даяаршилд чухал хувь нэмэр оруулжээ гэж үзэж болох юм.

Хубилай хааныг Эзэнт гүрний нийслэлийг шилжүүлж, Монгол нутгийг зах бөглүү муж болгосон хэмээн буруушаадаг хэдий ч Монголын өвөрмөц, давтагдашгүй соёл болох нүүдэлчний ахуй амьдралаа хамгаалан гадны их урсгал орохоос сэргийлэн тогтоож чадсан гэж үзэж болох юм. Мөн Хубилай хаан нь монгол угсаатан сүйрэх аюулыг зайлуулан гэтэлгэсэн агуу ухаантан юм.

Хубилай хаан монголчуудын нүдэнд Хятадад урвасан хэмээн адлагдаж, хятадуудад бүдүүлэг хэмээн харагддаг ч үнэндээ нүүдэлчин болон суурьшмал хоёр өөр соёлтой ард түмнүүдийг нэг хүний захиргаанд оруулан удирдаж чадсан нь түүний явуулж байсан бодлогын онцлог юм. Мөн Хятадыг бүхэлд нь эрхшээлдээ оруулан захирч байсан нь Их хаадын хүсэл зорилгод нийцсэн хэрэг байсан нь ч эргэлзээгүй юм.

Юан улсын болон Хубилай хааны үйл ажиллагааг нягтлан судалж, түүхэнд гүйцэтгэсэн үүргийг үнэлэн гаргах нь Эзэнт Их Гүрнийхээ түүхийг бодитоор тодруулан гаргахад чухал ач холбогдолтой билээ.

Ашигласан ном зохиол

1. "Монголын Эзэнт гүрний гадаад харилцаа" (XIII-XIV зуун), УБ 1995, тал 90
2. Олхунууд Хайнзангийн Шагдар "Монголчуудын ан дайн, цэргийн урлагийн түүх" (XIII зуун), УБ., 2000 он, тал 606
3. мөн тэнд, тал 713
4. мөн тэнд, тал 515
5. Докумэнто ширийзү 12, Мооко шюүрай 700 нэн, /Баримтат цуврал, Монголын довтолгооны 700 жил/ Нихон тэрэби хоосоомоо кабүшики кайшя, 1981, тал 58,
6. "Монгол улсын түүх", дэд боть УБ., 2003, тал 316
7. Т.Мөнхцэцэг, XIII-XIV зууны үеийн Монгол Японы харилцаа, УБ., 2004, тал 45
8. Б.Сумъяабаатар, Хубилай хаанаас Японы ванд илгээсэн жуу бичиг "Музей судлал", УБ., 2003, тал 61
10. Т.Мөнхцэцэг, XIII-XIV зууны үеийн Монгол Японы харилцаа, УБ., 2004, тал 72-73
11. Монгол Японы харилцаа: эрт, эдүгээ, Интерпресс хэвлэлийн газар, УБ., 2001, тал 37
12. George Sansom, A History of Japan to 1334, vol .1, p-444
13. Т.Мөнхцэцэг, XIII-XIV зууны үеийн Монгол Японы харилцаа, УБ., 2004, тал 76
14. George Sansom, A History of Japan to 1334, vol .1, p-449
15. Монгол Японы харилцаа эрт, эдүгээ, Интерпресс хэвлэлийн газар, УБ., 2001, тал 43